



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

Бүтэнцэр /м/ Мийн Ням /МОН/ МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТЭГЭЭЛЭЛЭГЭЙН ХЭРЭГЖИЛТЭД
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2022 оны IV улирлын байдлаар/

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ГАЗАР, НЭГЖҮҮДИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

/2022 оны IV улирлын байдлаар/

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН ГАЗАР, НЭГЖҮҮДИЙН
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2022 оны IV улирлын байдлаар/

2022-12-23

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Компанийн 2022 онд газар, нэгжүүдийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар Гүйцэтгэх удирдлага, холбогдох удирдах албан тушаалтныг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ холбогдох газар, нэгжүүдээс ирүүлсэн төлөвлөгөөний биелэлтэд тулгуурласан бөгөөд шаардлагатай тохиолдолд тодруулга, тайлбар явсан болно.

Хоёр. Танилцуулга

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил нь компанийн хэмжээнд анх жилдээ хийгдэж байгаагаараа онцлог байна. Өмнөх жилүүдэд газар, нэгжүүд тус тусдаа гүйцэтгэх ажлаа төлөвлөн хэрэгжүүлж, жилийн эцэст "Компанийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан" гэсэн баримт бичгийг Захиргаа, удирдлагын газраас нэгтгэн гаргаж ирсэн. Энэхүү баримт бичиг болон газруудын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаагүй байна.

"Компанийн 2022 оны үйл ажиллагааны нэгсэн төлөвлөгөө"-г Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн А/101 дүгээр тушаалд баталж, улирлы, үржлийн жил, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Захирлын зөвлөлийн хуралд танилцуулахыг үүрэг болгосны дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Мөн Гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/25 дугаар тушаалаар компанийн бүтцийн газар, алба, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх зарим ажил, үйл ажиллагааг шинэчилсэн бүтэц, чиг үүргийн дагуу /гадаад харилцааны чиг үүрэг ТХОГ-аас БХГ-т шилжсэн/ шилжүүлэн тооцож, хяналт-шинжилгээ хийсэн болно.

Газруудаас ирүүлсэн төлөвлөгөөний биелэлтээс энэхүү тайланд зөвхөн цаашид анхааран ажиллах, гүйцэтгэл тодорхойгүй, үнэлэх боломжгүй, хугацаа хоцорсон, тодорхой үр дүнд хүрээгүй ажлуудыг оруулсан болно.

Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт гаргаж ирүүлэх талаар 2022-12-05-ны өдөр бүх газар, нэгжүүдэд албаны и-мэйлээр мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг 2022-12-20-нд хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Дөрөв. САНАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

- Компанийн хэмжээнд хэрэгжүүлэх газар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг биелэгдэхүйц, тооцоо судалгаатай, тоо хэмжээгээр хэмжигдэхүйц, тодорхой үр дүнд хүрэхүйц, хэрэгжүүлэх цаг хугацаа тодорхой байхаар төлөвлөх шаардлагатай байна.
- Газар, нэгжүүдэд төлөвлөгөө гаргах, биелэлт ирүүлэх ажлыг хариуцсан ажилтныг томилон, ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг нэмэх /хариуцсан ажилтан байхгүйгээс төлөвлөгөөний биелэлт хугацаандаа ирүүлэхгүй удааширах, хугацаа хоцролттой, биелэлт дутуу, хийгдээгүй ажлуудыг шахаж, удирдлагуудад мэдэгдэх, зохих арга хэмжээ авах шаардлагатай/;
- Улирал тутам ирүүлж байгаа газар, нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг харьяалах газрын удирдлагууд танилцаж, хяналтын ажилтанд илгээхийг зөвшөөрсөн байх;
- Төлөвлөгөөний биелэлтийг тогтсон форматын дагуу газрын даргын гарын үсгээр баталгаажуулж цаасан хэлбэрээр өгөхөөс гадна цахим хэлбэрээр албаны и-мэйл ашиглан ирүүлж байх;
- Газар, нэгжүүд төлөвлөгөөний биелэлт гаргахдаа тухайн төлөвлөсөн ажлын хүрээнд ямар арга хэмжээ, үйл ажиллагаа явуулсан болон хүрсэн үр дүнгийн талаар үнэлж тайлагнаж байх;
- Биелэлтийг хэт товч, тодорхойгүй /судалж байна, хийгдэж байна гэх мэт/ бичихгүй байх, төлөвлөсөн ажлын хүрээнд гүйцэтгэж, явагдаж байгаа ажилбарыг товч, тодорхой бичих;
- Төлөвлөсөн хугацаанд биелээгүй ажлуудын шалтгаан, нөхцөл, тулгамдаж буй асуудлын талаар тайлбар бичих;
- Газар, нэгжүүдийн удирдлага төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллах;

~ ооо ~

2022-12-23

3.1. ДҮГНЭЛТ

Компанийн 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр хүлээн авч хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төлөвлөгөө батлуулахаас эхлээд хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах зэрэг үйл ажиллагаанд газар нэгжийн дарга, удирдлагууд тодорхой ач холбогдол өгч, анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн, биелэлтийн үнэлгээ, бусад үзүүлэлтийг харгалзан Гүйцэтгэх удирдлагын зүгээс хариуцлага тооцох, үр дүнд суурилсан урамшууллын асуудлыг /холбогдох журмын дагуу/ шийдвэрлэж байх нь зүйтэй байгаа бөгөөд энэ тохиолдолд газар, нэгжийн удирдлагууд төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах чиглэлд хариуцлагатай хандаж ажиллах хөшүүрэг болно гэж үзэж байна.

Энэхүү нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан зарим газар, нэгжийн хэрэгжүүлэх ажлуудад дараах алдаа дутагдал харагдаж байна. Үүнд:

- Сянхүүжилт, хөрөнгө оруулалт, зардлын асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй ажлууд төлөвлөх
- Засгийн газрын болон бусад эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр гараагүй, чиглэл өгөөгүй ажлуудыг төлөвлөх
- Чиг үүргийн хувьд хамааралгүй гадны байгууллагын хэрэгжүүлэх ажлыг татан оруулж төлөвлөсөн /ЗТХЯ-ны тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажлыг гишүүнээр орсон гэдэг үндэслэлээр газрын хэрэгжүүлэх ажил болгон төлөвлөсөн, төмөр замын мэргэжлийн зөвлөлийн гүйцэтгэх ажлыг ЗУГ-ын ажил болгон төлөвлөсөн/
- Газрын чиг үүргээс ангид бусад газар, нэгжийн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлыг татан давхардуулж төлөвлөсөн. /БХГ хүний нөөцийн менежментийн судалгаа, ТЛГ ХАБЭА сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах, автобус худалдан авах, ТХОГ Шивээхүрэн боомтын төмөр зам барих, ТТ-ЗБ төслийн баримт бичиг архив өгөх гэх мэт/
- Нэг ажлыг газар, нэгжүүд давхардуулж төлөвлөх /ТЛГ, ТХОГ, ТН чингэлэг тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх, ТЛГ, ИТГ экскаватор засварлуулах гэх мэт/

Мөн газар, нэгжүүдийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлууд хүндэтгэн үзэх дараах шалтгааны улмаас биелэгдээгүй байна. Үүнд:

- "Төрийн хэмнэлтийн тухай" хууль батлагдсантай холбоотой ТӨБЗГ, ЗТХЯ-ны албан даалгавраар хэрэгжилтийг хангах
- Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажилтай холбоотой эрх зүйн баримт бичиг гараагүй, батлагдаагүй /тогтоол, шийдвэр гараагүй/
- Хууль, шүүхийн шийдвэртэй холбоотой /Төмөртэйн тээвэрлэлт зогссон гэх мэт/
- Гадны байгууллагатай байгуулсан гэрээ, санамж бичиг цуцлагдсан
- 2022 оны бизнес төлөвлөгөөнд орсон тодотголоор хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнөөс хасагдсан ажлууд

Гурав. Нэгдсэн үнэлгээ
ГАЗАР, НЭГЖҮҮДИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Газрууд	Нийт заалт	Жилийн эцсийн байдлаар	Үүнээс						Биелэлтийн хувь
				90-100%	70-89%	50-69%	30-49%	10-29%	0%	
1	Захиргаа, удирдлагын газар	30	28	25	3				2	90.33%
2	Санхүү, эдийн засгийн газар	37	37	33	2	1	1			95.14%
3	Хууль, эрх зүйн газар	16	16	14	2					96.25%
4	Гадаад харилцаа, бизнес хөгжлийн газар	17	17	12	5					91.18%
5	Төсөл, хөрөнгө оруулалтын газар	9	9	5	3	1				84.44%
6	Тээвэр, логикийн газар	71	65	64		1			6	90.85%
7	Инженер, технологийн газар	93	83	77	5	1			10	87.10%
8	Төслийн нэгж	14	14	12	1		1			92.86%
9	Хяналт, шалгалтын газар	87	82	76	2	3	1		5	96.59%
10	Олон нийтийн харилцааны алба	20	19	16	3				1	90.50%
11	Төмөр замын зам, барилгын механикxсан анги	27	24	22	1		1		3	85.19%
дундаж үнэлгээ		421	394	356	27	7	4	0	27	90.95%